

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур Залуус төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/042/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас:70007734 Цахим хаяг: nandinjargalq@audit.gov.mn

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер:
Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

“Си Эс Ай аудит” ХХК-ийн захирал: М.Сэвжидмаа
Утас: 19001981. Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-13 № 556

танай _____-ны № _____-т

БАГАНУУР ЗАЛУУС ТӨВ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
М.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур Залуус Төв ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Багануур залуус Төв ОНӨААТҮГ нь нийт 18 харилцагчтай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж, түрээсийн орлогын гүйцэтгэл нь 99.3 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2025 оны 25/98 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1308 дугаар захирамжийг үндэслэн 897.5 сая төгрөгийн өртөгтэй Ахмадын хөгжлийн төвийн барилгыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

C:\Users\inarangua\Desktop\Бичир хэсэг 2026\2026-05-13\Бичир хэсэг 2026\05-13\1426250533

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 99.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	487,147.90	1,227,887.00
1.1.2	Дансны авлага	16,239,358.60	58,318,573.30
1.1.6	Бараа материал	19,196,017.04	17,312,741.37
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	35,922,523.54	76,859,201.67
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,731,180,587.00	3,547,195,879.34
1.2.2	Биет бус хөрөнгө	246,212.10	3,300,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,731,426,799.10	3,550,495,879.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,767,349,322.64	3,627,355,081.01
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	11,673,289.74	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	43,280,890.41	13,613,402.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг	12,030,807.56	10,894,708.41
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		16,782,121.88
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	66,984,987.71	41,290,232.52
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	66,984,987.71	41,290,232.52
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: - төрийн	2,839,872,920.00	3,740,638,604.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(139,508,585.07)	(154,573,755.51)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,700,364,334.93	3,586,064,848.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,767,349,322.64	3,627,355,081.01

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	272,085,323.17	360,474,179.71
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	272,085,323.17	360,474,179.71
8	Бусад орлого	227,609,315.79	150,024,876.08
9	Борлуулалт, маркетингийн зардал	807,454.53	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	512,001,318.19	519,690,634.29
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	45,706,464.56	5,933,900.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(58,820,598.32)	(15,125,478.50)
19	Орлогын татварын зардал		19,691.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(58,820,598.32)	(15,145,170.44)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(58,820,598.32)	(15,145,170.44)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(58,820,598.32)	(15,145,170.44)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01 сарын 31	2,839,872,920.00	-			-	-	(79,538,288.87)	2,760,334,631.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(1,149,697.88)	(1,149,697.88)
Залруулсан үлдэгдэл	2,839,872,920.00	-	-	-	-	-	(80,687,986.75)	2,759,184,933.25
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(3,189,194.00)			(58,820,598.32)	(62,009,792.32)
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт				3,189,194.00		-		3,189,194.00
2024 оны 12 сарын 31	2,839,872,920.00	-	-	-	-	-	(139,508,585.07)	2,700,364,334.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
Залруулсан үлдэгдэл	2,839,872,920.00	-	-	-	-	-	(139,508,585.07)	2,700,364,334.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(15,145,170.44)	(15,145,170.44)
Бусад дэлгэрэнгүй орлого								-
Өмчид гарсан өөрчлөлт	900,765,684.00						80,000.00	900,845,684.00
2025 оны 12 сарын 31	3,740,638,604.00	-	-	-	-	-	(154,573,755.51)	3,586,064,848.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	481,369,665.17	511,822,802.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	298,161,194.17	357,207,892.56
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	174,300,000.00	148,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,908,471.00	6,614,910.28
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	483,312,940.60	511,082,063.74
1.2.1	Ажиллагчдад төлсөн	216,826,541.27	208,109,521.23
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	45,045,875.26	46,459,787.84
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	131,237,147.90	85,801,536.98
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	76,769,387.53	77,773,604.85
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,168,567.92	68,073,119.05
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,265,420.72	22,353,675.81
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,943,275.43)	3,251,557.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,510,817.98
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(2,510,817.98)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,943,275.43)	740,739.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,430,423.33	487,147.90
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	487,147.90	1,227,887.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мян төгрөг/

№	Үзүүлэлт	2024 оны		2025 оны		Зөрүү	Хувь
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А. Үйл ажиллагааны үндсэн орлого							
1	Төсвийн санхүүжилт	174,300.0	174,300.0	148,000.0	148,000.0	-	100.0
2	Зуслангийн үйл ажиллагааны орлого	70,000.0	47,730.5	45,360.0	-	45,360.0	-
3	Түрээсийн орлого	242,459.9	272,085.3	344,997.7	344,659.7	338.1	99.9
4	Алданги торгуулийн орлого	-	774.8	-	1,909.4	(1,909.4)	-
5	Зогсоолын түрээсийн орлого	3,644.0	1,614.9	13,614.0	15,930.0	(2,316.0)	117.0
6	Бусад орлого	-	3,189.2	-	-	-	-
Нийт орлогын дүн		490,403.9	499,694.6	551,971.7	510,499.1	41,472.7	92.5
Б. Үйл ажиллагааны үндсэн зардал							
1	Цалин	248,220.0	250,125.5	269,388.9	245,157.9	24,231.0	91.0
2	Үр дүнгийн урамшуулал	17,000.0	7,960.0	19,050.2	6,243.4	12,806.9	32.8
3	Нийгмийн даатгалын шимтгэл	33,152.5	26,943.7	34,634.4	24,154.0	10,480.4	69.7
4	Ус, дулаан, халаалтын зардал	71,900.0	59,593.9	111,606.3	60,947.9	50,658.4	54.6
5	Цахилгааны зардал	15,780.0	12,088.7	21,980.0	14,397.3	7,582.7	65.5
6	Элэгдлийн зардал	75,586.3	81,466.8	86,199.0	84,207.4	1,991.6	97.7
7	Бичиг хэргийн зардал	2,686.4	2,926.7	3,476.0	4,111.0	(635.0)	118.3
8	Шуудан холбооны зардал	1,726.8	1,738.3	3,542.4	2,520.1	1,022.3	71.1
9	Засвар үйлчилгээний зардал	16,000.0	34,232.1	30,200.0	27,157.5	3,042.5	89.9
10	Тохижилтын зардал	-	-	2,000.0	-	2,000.0	-
11	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	17,744.0	25,046.1	34,060.0	23,930.5	10,129.5	70.3
12	Лифтний засвар үйлчилгээний зардал	1,260.0	1,250.2	1,340.0	1,725.0	(385.0)	128.7
13	Шатахууны зардал	-	3,887.3	2,000.0	1,200.0	800.0	60.0
14	Зар сурталчилгааны зардал	-	3,622.7	6,999.6	4,104.3	2,895.3	58.6
15	Банкны шимтгэл	156.0	107.0	156.0	104.9	51.1	67.2
17	Зуслангийн хүүхдийн хоол	61,250.0	44,399.5	30,240.0	-	30,240.0	-
18	Зуслангийн шатахуун	1,000.0	-	2,440.0	1,500.0	940.0	61.5
19	Лаг соруулах	2,400.0	1,526.6	2,400.0	2,000.0	400.0	83.3
20	Хог ачилтын зардал	3,054.0	1,357.2	3,054.0	1,500.0	1,554.0	49.1
21	Газрын төлбөр	330.0	242.9	330.0	45.3	284.7	13.7
22	Санхүүгийн сургалт, зөвлөгөө, үйлчилгээ /НБББББичиг/	-	-	10,000.0	10,000.0	-	100.0
23	Гадна фасад цэвэрлэгээ	-	-	3,000.0	-	3,000.0	-
24	Бусад зардал	-	-	-	10,618.0	(10,618.0)	-

Багануур Залуус төв ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Нийт зардлын дүн		569,246.0	558,515.2	678,096.8	525,624.5	152,472.3	77.5
В. Нийт ашиг, алдагдал						-	-
1	Үйл ажиллагааны бус зардал					-	-
5	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(78,842.2)	(58,820.6)	(126,125.1)	(15,125.5)	(110,999.6)	12.0
6	Татвар дараах ашиг (алдагдал)					-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(78,842.2)	(58,820.6)	(126,125.1)	(15,125.5)	(110,999.6)	12.0
Орлогын 1 төг-т ногдох зардал		1.2	1.1	1.2	1.0	0.2	83.8

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 920.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Аудитаар нийт 7,087.2 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрч 2 зөвлөмж өгсөн.

Нийт залруулагдаагүй 7,087.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд бусад орлого 920.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	920.0	1	920.1			1	920.1				
Дүн	1	920.1	1	920.1			1	920.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь Эй Би Эй ХХК-с 4,665.0 мянган төгрөг, Цээгий гоо сайхны салоноос 2,015.3 мянган төгрөг, Солонгос хэлний сургалтын төвөөс 406.9 мянган төгрөг нийт 7,087.2 мянган төгрөгийн авлагыг 2024 оноос хойш шийдвэрлүүлээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	7,087.23					1	7,087.2				
БНД-ийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсээс Тэмүүлэл зуслангийн үндсэн хөрөнгө 269,891.4 мянган төгрөгийг баланс хооронд шилжүүлж аваагүй байна.	1	-					1	-				
Дүн	2	7,087.2					2	7,087.2				